

МОНГОЛ БАНК-нд

2023 оны 01 дүгээр
сарын 20-ны өдөр

Улаанбаатар
хот

Ажлын тайлан хүргүүлэх тухай

“Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, хараат бус гишүүн П.Мөнх-Эрдэнэ миний бие Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 04 дүгээр улирлын ажлын тайланг хүргүүлж байна. Тайлант хугацаанд танхимаар болон цахимаар 5 удаа хуралдсан банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг даргалан оролцож, санал зөвлөмжөө өгч, шийдвэр гаргалтанд оролцсон. Үүнд:

Нэг. 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдөр “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалтад зааснаар эчнээ санал хураалтын хуудсаар гишүүдээс санал хурааж ТУЗ-ийн хурлын тогтоолыг гаргасан бөгөөд дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1. “Корреспондент банкны харилцаа тогтоох журам”-ыг хэлэлцэн батлах

Монгол банкны Хяналт шалгалтын газрын улсын байцаагчийн 2022 оны 09 дүгээр сарын 12 өдрийн 2022/070/001 дугаартай “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах тухай” мэдэгдэлд банкны хүчин төгөлдөр мөрдөж байгаа “Корреспондент банкны үйл ажиллагааг зохицуулсан журам”-ыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нийцүүлэн сайжруулж ТУЗ-ийн хурлаар батлуулан Монголбанканд ирүүлэх хугацаат үүргийг өгсний дагуу банкнаас журмын сайжруулалтыг хуульд нийцүүлэн хийж, ТУЗ хурлаар хэлэлцүүлэхэд оролцож журмын зохицуулалт, зарим заалтыг эзэнжүүлэн тодорхой тусгах талаар өөрийн саналаа хэлсэн. Сайжруулсан журмыг ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар 17-ны өдрийн Т/22/48 тоот тогтоолын хавсралтаар монгол, англи 2 хэлээр бичигдсэн хувилбарыг баталсан. ТУЗ-ийн гишүүд санал хураалтын хуудсаар саналаа хураалгаж 100% зөвшөөрч шийдвэрлэсэн. Тогтоолыг ТУЗ-ийн дарга миний бие баталгаажуулан гарын үсэг зурсан.

Хоёр. 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг танхимаар хуралдуулж дараах асуудлыг хэлэлцүүлсэн.

1. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос ТУЗХ-аар хэлэлцүүлэхээр оруулж ирсэн 3 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан. Үүнд:
 - 2022 оны санхүүгийн тайланд аудит хийх хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, гэрээ хэлцэл хийх эрх олгох
 - ТУЗ-ийн дэргэдэх ДАГ-ын захирлаар Г.Тэмүүжинг томилох талаар
 - ТУЗ-ийн дэргэдэх ДАГ-ын дотоод аудиторoor Г.Алтанзулыг томилох талаар
2. ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэл удирдлагын хорооноос ТУЗХ-аар хэлэлцүүлэхээр оруулж ирсэн 1 асуудлыг хэлэлцэж шийдвэр гаргасан.
 - Банкны өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийн үнийг тогтоох, худалдан борлуулах зөвшөөрөл олгох
3. Банкны Гүйцэтгэх удирдлагаас хэлэлцүүлсэн 2 асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд:
 - Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох
 - Тооцооны касс байгуулах талаар

ТУЗ хурлаар дээрх 6 асуудлыг хэлэлцэн хурлаас гишүүдийн 100% дэмжсэн саналаар 6 тогтоолыг гаргасан. Үүнд:

1. Үнийн саналаа ирүүлсэн 4 хөндлөнгийн аудитын байгууллагын талаар танилцаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүнд, ажлын туршлага, ажиллах багийн мэдлэг ур чадвар, үнийн санал зэрэгт тулгуурлан “БДО аудит” ХХК-тай гэрээ байгуулж, ирүүлсэн үнийн саналаар зардал гаргахыг зөвшөөрсөн Т/22/49 дугаартай тогтоолыг батласан.
2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны удирдлага доор ажлаа тайлагнан ажиллах чиг үүрэгтэй Дотоод аудитын газрын захирлаар туршилтын хугацаанд ажиллаж байсан Г.Тэмүүжинг томилж, гэрээг шинэчлэн байгуулах, цалингийн дүн тусгасан Т/22/53 дугаартай тогтоолыг батласан.
3. Дээрх газарт дотоод аудиторыг сонгон шалгаруулж Аудитын хорооноос санал болгосон Г.Алтанзулыг дотоод аудиторoor томилсон Т/22/54 тогтоолыг батласан.
4. Банкны өмчлөх бусад хөрөнгөд бүртгэлтэй 23 үл хөдлөх хөрөнгийн үнийг тогтоож, худалдан борлуулах зөвшөөрөл олгосон хавсралт бүхий Т/22/50 дугаартай тогтоолыг батласан.
5. Банкны гүйцэтгэх захирлын 440 тоот тушаалаар зах зээлд шинээр нэвтрүүлсэн “Ханган нийлүүлэгчийн зээл” бүтээгдэхүүнийг Номин холдинг ХХК, түүний нэгдэлд багтах компанитай хамтран ажилладаг ханган нийлүүлэгчдэд зориулан гаргах, хамтран ажиллах хэрэгцээ шаардлагын үүднээс сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах асуудлыг хэлэлцүүлсэн. КТХ-д зааснаар уг асуудлыг ТУЗ-ийн хараат бус, энэ асуудалд сонирхлын зөрчилгүй 2 гишүүний саналаар хэлэлцүүлэн, зөвшөөрөн шийдвэрлэж Т/22/51 дугаартай тогтоолыг гарган баталсан. Сонирхлын зөрчилгүй 2 гишүүн тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулсан.
6. Банкны үйл ажиллагааг харилцагчдад ойртуулах зорилгоор Чингэлтэй дүүргийн 18-р хороо, 7 буудалд байгуулагдаж байгаа нийслэлийн Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хөгжлийн төв байранд байгуулах тооцооны кассын ажилтны тоо, орон тооны төсвийг батлуулахаар хэлэлцүүлж ТУЗ гишүүд зөвшөөрч Т/22/52 тоот тогтоолыг батлан гаргасан.

ТУЗ-ийн даргын хувьд болон хэлэлцэж байгаа асуудалд сонирхлын зөрчилгүй гишүүний байр сууринаас хурлаас гарсан тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Гурав. 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахимаар хуралдуулж дараах асуудлыг хэлэлцсэн.

1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох талаар хэлэлцэх

Ариг банкны төв оффисын байранд ажилтнуудын хэрэгцээнд зориулан оффис тавилга худалдан авахтай холбоотой банкны “Бэлтгэн нийлүүлэгч, ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, тогтвортой худалдан авалт хийх журам”-ын дагуу гүйцэтгэх захирлын 2022 оны 08 сарын 16-ны өдөр батлан зарласан нээлттэй тендерт шалгуур үзүүлэлтийг ханган шалгарсан компани болох “Номин хоум стайл” ХХК-тай гэрээ байгуулах, худалдан авалт хийх нь сонирхлын зөрчилтэй тул гүйцэтгэх удирдлагаас уг асуудлыг ТУЗ-ийн хуралд оруулан хэлэлцүүлсэн. КТХ-д зааснаар уг асуудлыг ТУЗ-ийн хараат бус, энэ асуудалд сонирхлын зөрчилгүй 2 гишүүний саналаар хэлэлцүүлэн, зөвшөөрөн шийдвэрлэж Т/22/55 дугаартай тогтоолыг гарган баталсан. Сонирхлын зөрчилгүй 2 гишүүн тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Дөрөв. 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг танхимаар хуралдуулж дараах асуудлыг хэлэлцсэн.

1. Банкны 2023 оны төсөв, бүтэц, зохион , орон тооны төсвийн талаар хэлэлцэх
2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг чөлөөлөх, томилох талаар

Хурлаар банкны удирдлагын багаас 2023 онд хийх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, орон тоо, тэдгээртэй холбоотой зардлын төсөв зэргийг урьдчилсан байдлаар ТУЗ гишүүдэд танилцуулж, санал зөвлөмж авч нэмэн сайжруулан дахин хэлэлцүүлэхээр болсон.

Хэлэлцэх 2-р асуудлын хувьд Монголбанкны Ерөнхийлөгчийн батласан удирдамжтай Монголбанкны Хяналт шалгалтын газраас иж бүрэн шалгалт хийх баг Ариг банканд дээр ажиллаж байгаа учир шалгалт дуусах хүртэл хугацаагаар хойшлуулсан.

ТУЗ-ийн хурлаас ямар нэгэн тогтоол гараагүй.

Тав. 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдөр “Ариг банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг цахимаар хуралдуулж дараах асуудлыг хэлэлцсэн.

1. СТОУС 9 стандартыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах талаар
2. Түрээсийн гэрээ хийх зөвшөөрөл олгох талаар
3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох талаар

ТУЗ хурлаар дээрх 3 асуудлыг хэлэлцэн хурлаас гишүүдийн 100% дэмжсэн саналаар 3 тогтоолыг гаргасан. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, хөндлөнгийн аудит хийж байгаа аудитын компани болон зохицуулагч байгууллагаас гаргасан журмын хэрэгжилтийг хангах, банкны санхүүгийн үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэх үүднээс СТОУС 9 стандартыг нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээг авахаар 2 байгууллагаас ирүүлсэн үнийн санал, танилцуулгатай танилцаж “Прайс уотерхаус куперс аудит” ХХК-тай гэрээ байгуулж, ирүүлсэн үнийн саналаар зардал гаргахыг зөвшөөрсөн Т/22/56 дугаартай тогтоолыг батласан.
2. ТУЗ-ийн 2021 оны Т/27 тоот тогтоол, 2022 оны Т/22/38 тоот тогтоолоор эрх олгон хийсэн гэрээний түрээслүүлэгч тал өөрчлөгдсөн тул гэрээний талыг өөрчлөн хэлцэл хийх эрх олгосон Т/22/57 дугаартай тогтоолыг батласан.
3. Банкны төв оффисын засвар, барилгын ажлын гүйцэтгэлд мэргэжлийн үүднээс захиалагчийг төлөөлөн хяналт тавих хэрэгцээ шаардлагын үүднээс сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах асуудлыг хэлэлцүүлсэн. КТХ-д зааснаар уг асуудлыг ТУЗ-ийн хараат бус, энэ асуудалд сонирхлын зөрчилгүй 2 гишүүний саналаар хэлэлцүүлэн, “Силвэр тауэр” ХХК-тай гэрээ хийх эрх олгон шийдвэрлэж Т/22/58 дугаартай тогтоолыг гарган баталсан. Сонирхлын зөрчилгүй 2 гишүүн тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаан дээр хараат бус гишүүний хувьд бусад гишүүдтэй зарчмын зөрүүтэй байр суурь илэрхийлэгдээгүй болно. Мөн эдгээр хурлуудаар хэлэлцүүлсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг хуульд заасан байдлаар шийдвэрлэж, саналаа өгч баталгаажуулсан болно.

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТУЗ-ИЙН ДАРГА, ХАРААТ БУС ГИШҮҮН

П.МӨНХ-ЭРДЭНЭ